

МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧИЙН ЯВУУЛЖ БАЙГАА ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛДВЭРЛЭЛ
ҮЙЛЧИЛГЭЭ, АШИГЛАЖ БАЙГАА ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХҮН, МАЛ АМЬТНЫ
ЭРҮҮЛ МЭНД, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ БУЮУ ҮЗҮҮЛЖ БАЙГАА
НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



“ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, Эрчим хүчний яамнаас санаачилан түүний салбар байгууллагууд ногоон зурвас байгуулах ажлын хүрээнд Луус суманд 2023 оны 5 дугаар сард 1000 ширхэг модны суулгац суулгаж усалгааны системийг шийдвэрлэн Намрын ногоон өдрүүд ажлын хүрээнд 850 ширхэг улиас модны суулгац суулгаж намрын тариалалтыг “Ойн хайгуул” “ХХК хийж гүйцэтгэлээ.

Наран багийн нутаг Төгрөг хэмээх газарт иргэн Ж.Эрхэмбаяр нь гэр бүлээрээ 50га талбайд 7 төрлийн 600 ширхэг мод тариалж ургац 70 хувьтай байна.

Дундговь ЦТС нь сайн үйлсийн аяны хүрээнд 3 төрлийн 650 ширхэг модын сумын орон сууцны хорооллын хүүхдийн тоглоомын талбайд тарьж ургуулсан.

МАЛ, АМЬТНЫ СЭГ ЗЭМ УСТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН АЖИЛ



Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 01 дүгээр албан даалгавар, МЭЕГ-ын даргын А/34 дугаар тушаал, аймаг, сумын Засаг даргын захирамжийн хүрээнд аймгийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчин, хүн, мал амьтнаар дамжин халдварлах өвчин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор өвөлжөө, хаваржааны ойр орчмын малыг цуглуулж устгах, хашаа хороо, худаг уст цэг, цэвэрлэх халдваргүйтгэх ажлыг сумын Засаг даргын Тамгын газраас малчид иргэдтэй

хамтран үе шаттай зохион байгуулан ажиллаж байна.

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганчимгээр ахлуулсан ажлын хэсэг Суварга, Буянт, Наран багийн хорогдсон мал, амьтны сэг зэм устгалд үхэр, адуу, хонь, ямааний сэг зэмийг цуглуулан стандарт зааврын дагуу устгаж халваргүйтгэлийн ажлыг хийлээ. Малын бэлчээрт малын сэг, зэм байсан гуу жалга, энгэр, зэрэг газруудад нян, бактер, вирус устгах үйлчилгээтэй суперкилл бодисыг хуурайгаар үелүүлэн цацаж халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ. Мөн малын хорогдолтой айл, өрхөд ариутгалын бодис хүргэж анхааруулах зөвлөмж хүргэж ажиллалаа. Хамтран ажилласан Буянт багийн малчин Б.Жамьянгарав, Ц.Отгонбат, Суварга багийн малчин Н.Гантөгс, Г.Ганбаяр, Б.Дашбалбар, Н.Банзар, Н.Гантөмөр, хэсгийн цагдаа Б.Энхэхлэлт, Эрүүл мэндийн төвийн жолооч Д.Мөнхтогоо болон ЗДТГ-ын албан хаагчдадаа талархал илэрхийлье. Цаашид малчин та зүй бусын хорогдлын мэдээгээ үнэн зөвөөр өгч, сэг зэмээ гуу жалганд нуулгүй, бодит байдлыг үнэн зөвөөр мэдүүлж, малын сэг зэмээ сумын хогийн төвлөрсөн цэгт хүргэж эзэмшлийн бууц хороондоо гадны айл буулгасан бол хариуцлагаа хүлээж хуулийн өмнө хүлээсэн иргэний үүргээ биелүүлж байхыг анхаарна уу.

ШИНЭ ХӨДӨӨ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД



Шинэ хөдөө төслийн хүрээнд Явуулын мал уаалгын ванн, хашаа, хонь хяргах төхөөрөмж, цахилгаан үүсгүүр, хүлэмж, трактор, газар хагалах төхөөрөмж зэргийг хүлээн аваад байна. Хүлэмж: иргэд өөрсдөө ногоо тариалан эрүүл чанарлаг хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх Трактор, газар хагалах төхөөрөмжөөр газар хагалах, газар тариалан эрхлэхэд иргэдийн амьдралд чухал нөлөөтэй.